



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

UN-REDD
PROGRAMME



Food and Agriculture
Organization of the
United Nations



***“Ойн олон талт
үр ашгийг
нэмэгдүүлэх,
REDD+ ийн
төлөвлөлтөд
дэмжлэг үзүүлэх
орон зайн мэдээлэл”
сэдэвт семинар***

Хөтөлбөр

UN-REDD ХӨТӨЛБӨР

2016 оны 5 сарын 27

Танилцуулга

Энэхүү семинар Нэгдсэн Үндэсний Байгууллагын - Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах хөтөлбөрийн (UN-REDD programme) хүрээнд БОНХАЖЯ, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн (УЦУОСМХ) Байгаль орчны мэдээллийн төв (БОМТ) болон НҮБ-ын REDD+ хөтөлбөрийг төлөөлөн оролцож буй Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн Даян дэлхийг хамгаалах мониторингийн төвийн (НҮББОХ-ийн ДДХМТөв) хамтран хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааны нэг хэсэг юм.

Энэ үйл ажиллагааны гол зорилго нь REDD+-ийн төлөвлөлтөд шаардлагатай шийдвэр гаргахад ашиглах арга хэрэгслийг хөгжүүлэх, сэдэвчилсэн зурагт суурилсан дүн шинжилгээний үндсэн дээр Монгол орны REDD+-ээс хүртэх боломжит үр ашгийг нэмэгдүүлэх, учирч болох эрсдлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллагч түнш байгууллагуудын боловсон хучнийг чадавхижуулах явдал юм.

Энэхүү семинар нь УЦУОСМХ болон НҮББОХ-ийн ДДХМТөвөөс 2015 оны 10 сар, 2016 оны 3 сард Улаанбаатарт цуврал байдлаар зохион байгуулсан хоёр удаагийн техникийн хамтарсан зөвлөгөөн, мөн 2015 оны 11 сард төслийн сонгосон Төв болон Хөвсгөл аймагт зохион байгуулсан олон талт үр ашгийн талаарх зөвлөлдөх уулзалтын дараахь төгсгөлийн семинар юм.

Өмнөх техникийн хамтарсан зөвлөгөөнөөр газарзүйн мэдээллийн системийн эх код нь нээлттэй, үнэгүй, QGIS программыг ашиглан REDD+ ийн төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх орон зайн дүн шинжилгээ хийх газарзүйн системийн зарчим, арга технологи болон орон нутгийн түвшин дэхь REDD+ ийн боломжит үр ашгийг тогтоож REDD+ ийн төлөвлөлтөд ашиглах зураг боловсруулах талаар танилцуулсан. Энэхүү үйл ажиллагааны явцад Монгол орны тайгын бүсийн ойн болон 2 аймгийг хамарсан цуврал (хэд хэдэн) газрын зургийг хамтран боловсруулсан. Энэхүү газрын зургууд нь Төв болон Хөвсгөл аймгийн оролцогч талуудын тодорхойлсон ойгоос хүртэх чухал үр ашгийг тооцож үзэн REDD+ ийн боломжит хэд хэдэн давуу тал болон мөн түүнчлэн ойн өөрчлөлт, ойд учруулж байгаа нөлөөлөл зэрэг REDD+ ийн төлөвлөлтийн элементүүдийг харуулах боломжтой юм.

Семинарын гол зорилго нь байгалийн баялаг, газар, ус, ой зэрэг олон салбарын болон сонгосон 2 аймгийн төлөөллийг оролцуулан REDD+-ийн олон талт үр ашиг болон бусад элементүүдийн талаар цуглуулсан мэдлэгээ хуваалцах, мөн боловсруулсан дүн шинжилгээний үр дүнд санал зөвлөмж авахад оршино.

Семинарын зорилт

- REDD+ - ийн боломжит олон талт үр ашиг болон Монгол улсад хэрэгжиж байгаа бусад төлөвлөлтийн элементүүдийн талаар мэдлэг, мэдээлэл солилцох, ялангуяа Төв, Хөвсгөл аймгийн тайгын ойн бүс нутгийг хамарсан газрын зураг дээр төвлөрөн ярилцах
- Урьдчилан гаргасан газрын зурагт Монгол Улсын үндэсний болон аймгийн түвшний холбогдох байгууллагаас санал, зөвлөмж авах

Хүлээгдэж буй үр дүн

- REDD+ олон талт үр ашиг болон бусад төлөвлөлтийн элементүүд, мөн тэдгээрийг тодорхойлход орон зайн анализийг ашиглах талаар ахисан түвшний ойлголттой болох
- Эцсийн анализ болон түлхүүр дүгнэлтүүдийг гаргахад оролцогчдын саналыг тусгах


Семинар зохион байгуулах газар, огноо

Семинар нь 2016 оны 5 сарын 27-ны өдөр Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг Сонгинод Mongolica амралтын цогцолборт болно.

(Сонгины амралтын хойно) www.mglhotel.mn

Оролцогчид 5 сарын 27-ны өглөө 8 цагт Ус цаг уурын хүрээлэнгийн байрны гаднаас автобусаар явна.

Семинарын дараа хот руу буцаж автобусаар явна.



Оролцогчид:

Энэхүү семинарт ойролцоогоор 40 оролцогчид оролцоно. Үүнд :

- Төв болон Хөвсгөл аймаг (Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн анги)
- Төрийн байгууллага (БОНХАЖЯ, Аж үйлдвэрийн яам, Газрын харилцаа, Геодези зураг зүйн газар зэрэг)
- Судалгааны хүрээлэн, Их дээд сургууль (УЦУОСМХ, Ойн судалгаа хөгжлийн төв, МУИС, Ботаникийн хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургууль, Гео экологийн хүрээлэн зэрэг)
- Орон нутгийн болон иргэний нийгмийн байгууллагууд (Ойн, усны чиглэлийн ТББ-ууд)
- Монгол Улс дах НҮБ-ын REDD хөтөлбөр болон холбогдох бусад төсөл, хөтөлбөр (GIZ, FAO, UNDP)
- Техникийн зөвлөгөөнд оролцогчид

2016 оны 5 сарын 27-ны хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагаа	Илтгэгч
9:00 – 9:15	Нээлт	Хатагтай М. Тунгалаг (БОНХАЖЯ-ны ОБЗГ-ын дарга, UN-REDD үндэсний хөтөлбөрийн захирал) Ноён С. Хөдөлмөр (УЦУОСМХ-ийн захирал)
9:15 – 09:30	Монгол дахь REDD+ Монгол Улсын Үндэсний REDD + хөтөлбөр	Ноён Б. Хишигжаргал (UN-REDD хөтөлбөрийн менежер)
9:30 – 09:50	Тойм REDD+ - ийн орон зайн төлөвлөлтийн төсөл ба семинарын зорилго	Хатагтай З. Нарангэрэл (УЦУОСМХ- БОМТ Ойн мэргэжилтэн)
09:50 – 10:30	Оршил REDD+ олон талт үр ашиг болон орон зайн мэдээллийг ашиглан төлөвлөлтөнд дэмжлэг үзүүлэх	Хатагтай Шарлот Хикс (НҮББОХ-ДДХМТ)
10:30 – 11:00	<i>Цайны цаг</i>	
11:00 – 11:30	Газрын зураг Хэлэлцүүлгийн үед ярилцах зургуудын талаарх танилцуулга	Хатагтай Г. Нандин-Эрдэнэ (УЦУОСМХ-Зайнаас тандан судлах хэлтэс ГМС-ийн мэргэжилтэн)
11:30 – 12:00	Асуулт, хэлэлцүүлэг	Б. Хишигжаргал, З.Нарангэрэл, Шарлот Хикс
12:00 – 12:15	Багаар ажиллах Үдээс хойш багаар ажиллах дасгал ажлын танилцуулга	Шарлот Хикс (НҮББОХ-ДДХМТ)
12:15 – 13:15	<i>Үдийн хоол</i>	

13:15 – 15:30	<p>Багаар ажиллах</p> <p>Дөрвөн бүлэг болгон хувааж:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ойн бүсийн газрын зураг: нөлөөлөл 2. Ойн бүсийн газрын зураг: олон талт үр ашиг 3. Төв аймгийн газрын зураг 4. Хөвсгөл аймгийн газрын зураг <p>Баг тус бүр газрын зураг дээр ажиллаж, тодорхой асуултанд хариулах ба дараа нь бусад багтай солигдож санал бодлоо хуваалцана.</p>	УЦУОСМХ болон ТХН
15:30 – 16:00	<i>Цайны цаг</i>	
16:00 – 16:45	<p>Эргэж мэдээлэх</p> <p>Баг тус бүр нь боловсруулсан газрын зургийн түлхүүр ойлголт/дүгнэлт болон өөрсдийн эцсийн хариултыг тайлагнана.</p>	Багийн гишүүд
16:45 – 17:00	Хаалт	Хатагтай М. Тунгалаг (UN-REDD үндэсний хөтөлбөрийн захирал) / ноён Крис Дикинсон (UN-REDD-ийн зөвлөх)
17:30	<i>Оройн хоол</i>	